

БАТЛАВ: БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. **Аудитын нэр:** “2016, 2017 оны аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”

2. **Аудитын код:** ГАГ-БНАТАГ-/2018/-06-ГА

3. **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/06 тоот тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. **Аудитын зорилт**

Аудитын явцад дараах асуудалд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд

- Эмийн зардлыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулсан уу?
- Эмийн худалдан авалтыг хууль, журмын дагуу хийж, бүртгэлд бүрэн тусгасан уу?
- Санхүүгийн тайланд авлага, өглөгийг үнэн зөв тусгаж, хяналтыг хэрэгжүүлсэн үү?

5. **Аудитын хамрах хүрээ**

Аудитад аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016, 2017 оны эмийн зардлыг хамруулж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгээс авсан санхүүгийн тайлан, анхан шатны баримт, тушаал шийдвэр, журам, заавар, мэдээ, тайлан, судалгаа бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийнэ.

6. **Үндсэн мэдээлэл:**

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн орны тоог 2015 онд 280, 2016-2017 онд 295-аар баталсан бөгөөд төсвийн төсөлд эмийн зардлыг өмнөх оны зардлын гүйцэтгэлд суурилж төлөвлөжээ.

2016, 2017 оны эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэл, батлагдсан төсөв, гүйцэтгэл, зарцуулалтыг харьцуулж авч үзвэл дараахь байдалтай байна.

Тайлант он	Эм боох материалын эхний үлдэгдэл	Төсвийн төсөлд тусгасан дүн	Батлагдсан төсөв	Худалдан авалт	Зардлын хэтрэлт, хэмнэлт	Зарцуулалт	/сая.төг/
							Эм боох материалын эхний үлдэгдэл
2016	73,1	1216.9	1161	1156.3	4.7	1058,1	171,3
2017	171,3	1399.8	1183.4	1158	25.4	1201,1	128,2

Тайлант онуудад эмийн зардлын хэмнэлтийг зарцуулалгүй төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хэвтэн эмчлүүлэгчийн өөрөөс хэрэглэсэн эмийн үнэнд 2016 онд 22 хүнд 2,7 сая, 2017 онд 30 хүнд 4,5 сая төгрөгийг олгосон байна.

Нэгдсэн эмнэлэг нь эмийн сан-нөөц, эмийн сан-эм олгох, найрлага шингэн, гемодиализ, хүчилтөрөгч гэсэн хэсгүүдээр дамжуулан эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг олгодог байна.

Аудитад хамрагдаж буй онуудад санхүүгийн тайланд эмийн авлага, өглөг тусгаагүй боловч 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 эм бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай тулган баталгаажуулалт хийхэд эхний болон эцсийн үлдэгдэл зөрүүтэйтэй байсан ба санхүүгийн тайланд өглөгийг үнэн зөв илэрхийсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна. Мөн 2017 оны санхүүгийн тайланд хийгдэх 5,3 сая төгрөгийн залруулгыг 2016 онд залруулж буруу бүртгэсэн байна.

## 7.Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн өмнөх шатанд цуглуулсан баримт материал, урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг "ИХ" гэж үнэлэв (Эрсдэлийн үнэлгээг хавсралт № 1-ээс үзнэ үү.)

## 8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж асуулга лавлагаа, тодруулга авч, санхүүгийн тайлан, статистик мэдээ, тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

## 9.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан

авах тухай хууль

- Эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль /2011 оны 05 дугаар сарын 05-ны өдөр/
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай Монгол улсын хууль /2010 оны 5 дугаар сарын 27-ны өдөр/
- Мансуурах эм, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай Монгол улсын хууль /2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр/
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай /УИХ-ын тогтоол 2014 оны 10 дугаар сарын 19-ны өдөр №57 /
- Үндэсний хөтөлбөр батлах тухай /МУ-ын ЗГ-ын тогтоол 2017 оны 04 сарын 12-ны өдөр №112 /
- Эмийн Эмчилгээг Зохицуулах Хороо ажиллах журам батлах тухай /ЭМС-ын 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 336-р тушаал/
- Мансуурах, сэтгэц нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай /ЭМС-ын 68-р тушаал/
- Журамд өөрчлөлт оруулах тухай /ЭМС-ын тушаал 2016 оны 05 сарын 18-ны өдөр/
- Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай /ЭМС-ын 2009 оны 11 сарын 17-ны өдөр 388 дугаар тушаал/
- Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлж журам /ЭМС-ын 2010 оны 378 дугаар тушаал/
- Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журмын тухай /ЭМС, СС-ын хамтарсан 2012 оны 04 сарын 20-ны өдөр №129/100 тушаал/
- Жагсаалт шинэчлэн батлах тухай /Зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалт/ /ЭМС-ын тушаал 2017 оны 09 сарын 07-ны өдөр А/350 /
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Холбогдох бусад эрхийн актууд

#### **10. Аудит хийх хугацаа**

Гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн өмнөх шатны ажлыг 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдөр эхэлж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2018 оны 07 дугаар сарын 04-нд батлуулж, ажиллагсдын ээлжийн амралт эхэлсэн тул аудитын гүйцэтгэлийн шатны ажлыг 2018 оны 08 дугаар сарын 13-ний өдөр эхэлж, 08 дугаар сарын 31-ний өдөр газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох газруудад тайланг хүргүүлнэ.

#### **11. Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны чанарын

хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл, Б.Азбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

**12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц**

**а. Боловсон хүчин:** 4 хүн \*26 өдөр =104 хүн/өдөр

**б. Санхүүгийн нөөц:** Цалингийн зардал 2,5 сая, томилолтын зардал 1,0 сая, бичиг хэргийн зардал 0,1 сая, нийт 3,6 сая төгрөг.

**в. Техник хэрэгсэл:** Зөөврийн компьютер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг:

Хянасан: Аудитын менежер

 Д.Цэцэгмаа

Боловсруулсан: Ахлах аудитор

 Б.Должмаа

Аудитор

 П.Мөнх-Эрдэнэ

Аудитор

 Б.Нарангэрэл

2018 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

“2016, 2017 оны аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”

